



ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Архивын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.2, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Үндэсний архивын газар”-ын даргын тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 2.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын баримт бичгийн үнэ цэнийг нягтлан шалгах, байнгын хадгалалтанд баримт сонгох болон шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах зорилгоор Баримт бичиг нягтлан шалгах комисс /БНШК/-ыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Комиссын дарга Г.Балжинням

Дэд захирал бөгөөд ерөнхий диспетчер

Нарийн бичгийн дарга: Д.Пагмаа

Архив, бичиг хэргийн эрхлэгч

Гишүүд:

Д.Алимаа

Хүний нөөцийн мэргэжилтэн

Ц.Энхсайхан

Ахлах инженер

Л.Бямбацэнд

Диспетчер инженер

Д.Мягмарсүрэн

Зах зээлийн гэрээний мэргэжилтэн

Б.Онон

Компьютерийн техникч

Б.Отгонханд

Дулааны тооцооны инженер

2. БНШК нь “Архивын тухай хууль”, “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ыг мөрдөн, төрийн архивын дэргэдэх “Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комисс”-оос арга зүйн зөвөлгөө авч “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт” гарган батлуулж ажиллахыг комисс /Г.Балжинням/-т даалгасугай.
3. Байгууллагын баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримт бүрдүүлэгч албадаас авч төрөлжүүлэн хэрэг бүрдүүлэх, албан хэрэгт хөтлөгдөх хугацаа дуусмагц зохих журмын дагуу цэгцэлж, бүрэн бүрдэлтэйгээр байгууллагын архивт шилжүүлэх ажлыг комисс /Г.Балжинням/-д хариуцуулсугай.
4. Архив, бичиг хэргийн ажилтныг зориулалтын өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл болон архивын холбогдолтой ном, сэтгүүл, гарын авлагаар хангах, архивыг сайжруулах, боловсронгуй болгох ажлыг Удирдлага, санхүүгийн алба /Ц.Мартгэрэл/-нд даалгасугай
5. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага, санхүүгийн алба /Ц.Мартгэрэл/-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.ЦОГТБААТАР